ХЭНТИЙ АЙМГИЙН
БИНДЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 16 өдөр Дугаар А/58 Биндэр сум

Мал амьтны сэг зэм устгал,
орчны цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн
арга хэмжээ зохион байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 7.3,6 дахь заалт , 19 дүгээр зүйлийн 19.2.4 , 19.2.6 , Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2026 оны А/29 дүгээр тушаал, Хэнтий аймгийн Засаг даргын 2026 оны А/157 дугаар захирамж, Хэнтий аймгийн Мал эмнэлгийн газрын даргын 2026 оны А/23 дугаар тушаал тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Мал, амьтны сэг зэм устгал, орчны цэвэрлэгээ халдваргүйтгэлийн арга хэмжээг сумын хэмжээнд зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй баталсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Х.Гэлэгжамц	Мал эмнэлгийн тасгийн дарга
Гишүүд:	Н.Болормаа	1-р багийн Засаг дарга
	Э.Мөнгөншагай	2-р багийн Засаг дарга
	Ж.Ганзоригт	3-р багийн Засаг дарга
	Х.Амарзаяа	4-багийн Засаг дарга
	Б.Тунгалаг	5-р багийн Засаг дарга
Нарийн бичгийн дарга:	Ц.Цогтбаатар	Мал эмнэлгийн тасгийн мэргэжилтэн

2.Мал, амьтны сэг зэмээс малын халдварт өвчин тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор сэг ,зэм цуглуулж устгах, орчны цэвэрлэгээ халдваргүйтгэл хийх ажлын 2026 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн 2026 оны 10 дугаар сарын 30-ны дуустал хугацаанд зохион байгуулсугай.

3.Мал эмнэлгийн төлөвлөгөөг арга хэмжээг орон нутагтаа графикт хугацаанд нь шуурхай хийж гүйцэтгэхийг Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малын эмч нарт, Мал амьтны сэг, зэмийг цуглуулж устгах, орчны халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулахад шаардлагатай халдваргүйтгэлийн бодис, хамгаалах хувцас хэрэгсэл, мэргэжил арга зүйн заавар зөвлөмжөөр хангаж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн мэргэжилтэн (Ц.Цогтбаатар)-т даалгасугай.

4.Мал, амьтны сэг зэм устгал, орчны цэвэрлэгээ халдваргүйтгэлийн арга хэмжээнд шаардагдах хүн хүч, шатахуунаар хангаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Өнөболд)-д, Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (М.Отгонбаяр)-д, ажлын гүйцэтгэлийг танилцуулж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн дарга (Х.Гэлэгжамц)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Ц.ДЭМБЭРЭЛСАЙХАН

D/My document/Захирамж төсөл 2026